



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 14

№ 01/35 ДУА-2018/1/СТА-ОМТС Мандалговь хот

Зөрчлийг арилгуулах тухай

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дэрэн сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад сум хөгжүүлэх сангийн 460,000.00 /Дөрвөн зуун жаран мянга/ төгрөгөөр тэмцээн уралдаан зохион байгуулсан, сургалт, сурталчилгааны арга хэмжээнд оролцогчдод хоол авч төсвийг үр ашиг, хэмнэлтгүй, зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/, мөн хуулийн 6.4.1-д /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 1.8-д /Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна./, 1.9.-д /Сангийн хөрөнгийг энэ журмын 1.5, 1.8-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно./ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-т /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар, батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Сангийн хөрөнгийг “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын дагуу үр ашигтай зарцуулж байх.

Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 03 дугаар сарын 25-ний дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Дэрэн сумын Засаг дарга Н.Мядагмаа, нягтлан бодогч С.Цэдэрлхам нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

**ӨГСӨН:**  
АХЛАХ АУДИТОР  Ч.БЭРХСАЙХАН



4817144213  
ЗЮА0039 9033475

**ЗӨВШӨӨРСӨН:**  
ЗАСАГ ДАРГА  Н.МЯДАГМАА  
НЯГТЛАН БОДОГЧ  С.ЦЭДЭРЛХАМ



<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.